



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ

2013 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 11

Улаанбаатар хот

### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.9 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийг үндэслэн Төрийн байгуулалтын байнгын хорооноос ТОГТООХ нь:

1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн болон Байнгын хорооны хуралдааны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

#### Ажлын хэсгийн ахлагч:

Р.Гончигдорж - Улсын Их Хурлын дэд дарга

#### Гишүүдэд:

Н.Батцэрэг - Улсын Их Хурлын гишүүн  
С.Дэмбэрэл - Улсын Их Хурлын гишүүн  
Б.Наранхүү - Улсын Их Хурлын гишүүн  
Л.Цог - Улсын Их Хурлын гишүүн  
Х.Тэмүүжин - Улсын Их Хурлын гишүүн  
М.Энхболд - Улсын Их Хурлын гишүүн


Ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх дэд хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

Б.Баасандорж - Хууль зүйн яамны Нэгдсэн бодлогын газрын дарга  
Ө.Энхтөр - Авлигатай тэмцэх газрын Мөрдөн байцаах хэлстийн дарга  
Ц.Хүрэлбаатар - Тагнуулын ерөнхий газрын Эрх зүйн хэлтсийн дарга  
О.Батбилэг - Санхүүгийн зохицуулах хорооны Эрх зүйн хэлтсийн дарга  
Д.Төмөрбат - Монгол банкны Санхүүгийн мэдээллийн албаны дарга  
Ч.Энхбат - УАБЗ-ийн ажлын албаны референт

- |             |  |
|-------------|--|
| Д.Энхбат    | -Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээний хэлтсийн экспертийн албаны зөвлөх |
| М.Элбэгдорж | -Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны зөвлөх                                 |
| С.Энхцэцэг  | -Төрийн байгуулалтын байнгын хорооны ажлын албаны референт                               |

2.Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг 2013 оны 12 дугаар сард багтаан Байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Р.Гончигдорж)-д даалгасугай.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА



А.БАКЕЙ